

Хятаны Ляо улсын умард хилийн бэхлэлт, хэрмийн судалгааны зарим асуудалд

Чан Шяожөн^{1,*}

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Хятаны умард хилийн бэхлэлт, хэрмийн судалгааны түүхэн байр суурь, баригдсан болон ашиглаж байсан цаг хугацааны тухай асуудлыг хөндөхийг оролджээ. Судалгааны байдлаас үзвэл, “Чингисийн далан”-гийн хойд шугамыг Хятаны Ляо улсын үед (916-1125) байгуулсан бөгөөд Зүрчидийн Алтан улсын үед (1115-1234) залган ашиглаж байжээ. Зарим бэхлэлтийг 1147 онд Монголчууд булаан авч байсан бөгөөд Монгол Улсын Дорнод аймгийн Чойбалсан сумын нутаг Урд гэргийн говийн бэхлэлтээс хожим Юань улсын үед ч ашиглаж байсан байж болзошгүй он цагийн материал илэрчээ. “Чингисийн далан” хэмээх байгууламж нь умардын нүүдэлчин үндэстний довтолгооноос сэргийлэх, дайралтыг тогтоон барьж өмнө зүгт байгаа сэргийлэлтийн хэдэн давхар шугам хийгээд гол хот сууринд мэдээ хүргэх цаг хожих, хүн амын шилжилт хөдөлгөөнийг хянах, зам харилцаа, татвар хураалт, бэлчээрийн зохицуулалт гэх мэт олон чиг үүрэгтэй байгуулагдсан бололтой. Одоо ч гэсэн “Хэрмэн зам” хэмээх тал нутгийн зам харилцааны үүргээ биелүүлсээр байгаа билээ.

Түлхүүр үг: Хятан, Ляо, “Чингисийн далан”, хилийн бэхлэлт хэрэм

Удиртгал

Монголын өндөрлөгт төр улсаа байгуулж ирсэн нүүдэлчин үндэсний дотроос хамгийн арвин хот балгад цогцолсон нь Хятан нар болно. Хятан улсын хот суурин нь хааны орд харш бүхий 5 нийслэл хот, чжоу сяны, олзлогдсон иргэдийн, худалдааны, тахил тайлга ба онгон булшны сахиул хот, хилийн сэргийлэлтийн хэрэм бэхлэлт, дарангуй цэрэг суух хот гэх мэт олон төрөл байжээ. Сурвалжийн мэдээгээр, хятан нар 908-916 оны хооронд хойд, зүүн хойд болон баруун зүгийн нүүдэлчин улс аймгуудын эсрэг аян дайныг эхлүүлсэн бөгөөд 924 онд Орхоны хөндий дэх Уйгурын нийслэлд ирж дайны ялалтаа хөшөө чулуунаа сийлэн тэмдэглэсэн гэдэг.

Хятан нар Х зууны сүүл үеэс өнөөгийн Монгол Улсын нутагт Хэрлэн, Туул голын сав газар Баруун, Зүүн хэрэм, Хэрлэн Барс, Хар бух, Чин толгой, Улаан хэрэм зэрэг газар орон нутгийн нүүдэлчдийг дарангуйлах цэрэг суулгах, тэдний аж ахуйг хангах зорилготой хэд хэдэн хот байгуулжээ. Чингэхдээ, Орхон, Туулын сав газар байсан Уйгурын орхигдсон хуучин хот балгадыг засаж сэлбэж ашиглаж байсан нь мэдэгддэг. Хятаны эдгээр хэрэм бэхлэлтүүд нь гүн суваг, шуудуугаар хүрээлэгдсэн, өндөр зузаан бөх бат хана хэрэмтэй байдаг нь нутгийн монгол аймгуудын эсэргүүцэл, тэмцлээс ихээхэн болгоомжилж байсныг харуулдаг (Батсайхан нар 2017: 247).

Хятаны Ляо улсын умард хилийн бэхлэлтийн шугам ба “Чингисийн далан”

Сүүлийн жилүүдэд, Хятаны Ляо улсын умард хилийн сэргийлэлтийн хэрэм бэхлэлтийн судалгаа эрчимжиж, өнөөгийн Монгол, Орос, Хятад гурван улс дамнан орших “Чингисийн далан” гэж нэрлэгддэг дурсгалыг нарийвчлан судлах олон улсын төсөл хэрэгжин судалгааныхаа үр дүнгээс хэвлэн нийтэлж байгаа нь уг дурсгалын он цагийг нарийвчлан тогтоох, түүний бүтэц, зохион байгуулалтаар дамжуулан тухайн үеийн хил хязгаарын зохион байгуулалт, улс төрийн харилцаа, засаг захиргааны хяналт, нүүдэлчдийн хөдлөл байрлал зэргийг ойлгоход чухал материалаар хангаж байна.

Түүх археологийн судалгааны материалаас авч үзвэл, “Чингисийн далан” гэж нэрлэгддэг дурсгал гурав байдаг. Хамгийн хойд талд, одоогийн БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөнбуйрын Эргүнэ хотын Шангкүл дүүргээс хуучин Барга хошууны хойгуур гарч, ОХУ-ын хил рүү орж, Өвөр Байгалын хязгаарын Хайлаастай, Забайкальскаар дамжин, дахин Хөлөнбуйрын Манжуур хот руу орж, Шинэ Барга хошуугаар дайрч, Монгол Улсын хил рүү орж, Дорнод аймгийн Чойбалсан, Гурванзагал, Цагаан-Овоо, Сэргэлэн, Баян-Уул, Хэнтий аймгийн Норовлин, Баян-Адрага сумын нутаг хүрдэг. Нутгийн иргэд “Чингисийн далан”, “Хэрмэн зам” гэж нэрлэдэг, зүүнээс баруун тийш нийт 746 км үргэлжилсэн, нэг эгнээ шороон далангийн үлдэгдлийн өндөр нь 1–2 метр, хойд талд байх шуудууны гүн нь ойролцоогоор 1 метр бөгөөд

¹ МУИС, ШУС, Антропологи, Археологийн тэнхимийн докторант

* Холбоо барих зохиогч: 18304878143@163.com

уг бүтцийн өмнө талд хоорондоо тодорхой зайтай байрласан 56 бэхлэлт байдаг. Судлаачид уг шороон даланг Ляо улс барьсан гэдэг санал дээр нэгдэж байгаа бөгөөд Хятан улсын умард хилийн сэргийлэлтийн хойд шугам гэж нэрлэж байна.

Энэхүү шороон далангаас өмнө зүгт бас нэг шугам байх бөгөөд “зүүн хойд зам”, “ринхуан зам”, “баруун хойд зам”, “баруун урд зам” гэсэн 4 хэсэг далангаас бүрдэнэ. БНХАУ-ын Хармөрөн мужийн Чичихар хот, ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот, Хянганы аймаг дамжин, зарим шугам нь Монгол Улсын Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутгаар орж, эргээд Өвөр Монголын Тонглюа хот, Улаанхад хот, Улаанцав хот, Бугат хот, Хэбэй мужийн Чэндэ хотын Феннин Манж үндэстний өөртөө засах саяны нутаг дамжин үргэлжилдэг. Хятадын судлаачид түүнийг Зүрчидийн Алтан улсын үед баригдсан гэж үздэг бөгөөд БНХАУ-ын Төрийн зөвлөлөөс хүлээн зөвшөөрсөн соёлын өвийн жагсаалтанд “Алтан улсын далан” гэдэг нэрээр бүртгэгдсэн (Хүсэл 2021: 138).

“Чингис хаан” нэртэй гурав дахь шороон далан БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алшаа аймаг, Урадын хошуу, Дарханмуяанган холбоот хошууны нутгаар дамжин Монгол Улсын хилээр орж, Өмнөговь аймгийн Ноён, Хүрмэн, Баяндалай, Номгон гэсэн 4 сумын нутгийг дамжин зарим газраа тасран 320 гаруй км урт үргэлжилсээр Монгол Улсын хилээс гарч БНХАУ-ын Өвөр Монголын нийслэл Хөх хотыг чиглэн үргэлжилдэг. Далангийн нийт урт 800 гаруй км гэх бөгөөд зарим газар шороогоор, зарим газар чулуу, шороо, заг хольж барьсан байдаг. Далангийн өмнө талаар буй зарим бэхлэлт хэрмэнд хийсэн малтлагаар Тангудын Баруун Ся улсын (1038-1227) үед хамаарна гэсэн он цаг гарчээ (Ковалев, Эрдэнэбаатар 2021; Эрдэнэбат нар 2022: 219).

“Чингисийн далан” хэмээн нэрлэгддэг эдгээр хэрмийн гарал үүсэл, цаг үе, зориулалтын талаар эрдэмтдийн дунд олон янзын таамаг, судалгаа явагдсаар ирсэн. Эдгээр судалгааг тоймлон авч үзвэл, 1735 онд германы эрдэмтэн Герхард Мюллер, 1738 онд Паллас нар тухайн хэрмийн талаар анхны тэмдэглэл хийсэн байдаг. Үүний дараа, 1865 онд оросын газарзүйч П.А.Кропоткин тухайн нутгаар аялсан үедээ хэрмийн талаар ажиглалт хийж, 1897 онд А.М.Позднеев, 1901 онд Г.Н.Потанин, 1934 онд В.В.Поносов, 1950 онд С.В. Киселев нар хэрмийн байршил, бүтэц, хэлбэр зэргийг тэмдэглэн үлдээж, дараагийн үеийн судалгаанд үнэтэй мэдээлэл үлдээжээ (Крадин нар 2019).

Монгол Улсын нэрт эрдэмтэн Х. Пэрлээ 1961 онд энэхүү хэрмийг “Монголын Нууц Товчоо”-ны 281-р зүйлд дурдагддаг, Өгэдэй хаан нутгийн гөрөөсийг ах дүүгийн нутагт явна гэж харамлан 1228-1241 онд бариулсан “qurū’a yu’urqa” мөн болов уу гэсэн таамаг дэвшүүлсэн байдаг (Пэрлээ 1961: 103-104).

2005–2006 онд Монгол Улсын Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн Хятадын талтай хамтран “Монгол орон дахь археологийн судалгаа (2005–2006)” нэртэй төсөл хэрэгжүүлж, Хэнтий аймгийн Норовлин сумын нутагт орших “Чингисийн далан”-гийн хэсэгт малтлага, судалгаа хийжээ. Судалгааны дүнг харьцуулбал, Хятадын талаас энэхүү байгууламжийг “Алтан улсын үеийн хэрэм” хэмээн тодорхойлсон бол, Монголын тайланд уг хэрэм нь Ляо болон Алтан улсын аль нэгэн үед хамаарах нь тодорхойгүй гэсэн байр суурийг илэрхийлсэн байдаг (Мацукава 2021: 33).

2008 оноос эхэлсэн Монгол-Оросын хамтарсан археологийн судалгааны төсөл үр дүнгээ “Хятан улсын их хэрэм: Чингисийн далангийн зүүн хойд хэсгийн судалгаа” нэртэйгээр 2020 онд хэвлэн нийтэлснээр тус далангийн талаарх судалгаа маш гүнзгийрсэн юм. Судалгааны явцад далангийн дагуу байрлах хэрэм бэхлэлтүүдийг дугаарлан бүртгэж дөрвөлжин, дугуй, хосолсон бүтэцтэйг баримтжуулж, үүргийн хувьд ажиглалт, зогсоол, хяналтын цэг, мал аж ахуйн хориг, тээвэр-удирдлагын суурингийн үүрэгтэй байж болзошгүй гэжээ. Зарим нь усны эх, уулзвар газар, суурин нүүдлийн маршрут дээр төвлөрсөн байдал нь тэдгээрийг “хот балгас” бус, харин захиргаа-цэргийн хяналтын бүтэцтэй байсан болохыг харуулна гэж үзжээ (Крадин нар 2020).

2018-2019 оны үеэс Монгол-Израиль-Америк гурван улсын хамтарсан “Дорнод Монголын хэрэмт хотын судалгаа” төсөл хэрэгжиж Монгол Улсын Дорнод, Сүхбаатар, Өмнөговь аймгийн нутаг буй “Чингисийн далан” хэмээх дурсгалыг археологи, түүх, газарзүйн үүднээс судалж байна (Амартүвшин 2021). Тэдний судалгаанд дурдсанаар, тус хэрэм нь зөвхөн цэргийн хамгаалалтын байгууламж бус, харин хил хязгаарын захиргааны хяналт, нүүдэл хөдөлгөөний зохицуулалт, татвар хураалт, бүс нутгийн хяналт зэрэг олон үүргийг хавсран гүйцэтгэж байсан “хэрэм–бэхлэлт–суурин” хосолсон систем байсан гэж үзжээ. Гидеон Шелах-Лави нарын туурвисан “Монголын тал нутагт нийтийн тооллын XI-XIII зууны үед баригдсан урт далан хэрмийн тухай” өгүүлэлд Чингисийн далангийн 700 гаруй км урттай хойд шугамын тухай судалгааны үр дүнг танилцуулжээ. Судалгаанд хиймэл дагуулын зураглал, дроны зураг, GPS хэмжилт болон археологийн хээрийн шинжилгээний аргыг ашиглаж, нийт 42 бүлэгт хамаарах 72 байгууламж илрүүлсэн байна. Судлаачид уг хэрмийг цэргийн зориулалттай хамгаалалтын байгууламж гэхээсээ илүүтэйгээр хүн амын шилжилт хөдөлгөөн, бараа таваарын эргэлтийг хянах, татвар хураах, өртөө замын урсгалыг зохицуулах зорилготой захиргааны байгууламж байсан гэж дүгнэсэн. Хэрмийн дагуу байрлах дөрвөлжин туурь бүхий отгуудыг хяналтын цэг, зарим том дугуй байгууламжийг малын

хашаа эсвэл хилийн худалдааны талбай байж болох хэмээн үзжээ. Мөн энэхүү байгууламж нь тухайн үед тохиолдож байсан уур амьсгалын огцом өөрчлөлт, тухайлбал зуд зэрэг байгалийн гамшгийн улмаас үүссэн нүүдэлчдийн дайралтад хариу үйлдэл үзүүлэх, нүүдэлчдийг төвшитгөх зорилготой байсан болов уу гэж тайлбарласан байна (Gideon *et al.* 2020; Bryan *et al.* 2024).

2021 оноос Монгол Улсын Их Сургууль, Японы Шова Эмэгтэйчүүдийн Их Сургууль хамтарсан “Чингисийн далан: Олон улсын хамтын ажиллагаа” төсөл зохион байгуулагдаж Монгол Улсын Дорнод аймгийн Чойбалсан, Сэргэлэн, Баян-Уул сумын нутагт Чингисийн далангийн дагуу орших 4 бэхлэлтэнд малтлага хийж олдворын харьцуулсан судалгаа болон C14 лабораторийн шинжилгээгээр Хятаны Ляо улсад анх байгуулагдсан бөгөөд зарим бэхлэлтийг түүнээс хожуу үед, тухайлбал Дорнод аймгийн Чойбалсан сумын нутаг Урд гэргийн говийн бэхлэлтээс Юань улсын үед ашиглаж байсан байж болзошгүй он цагийн сонирхолтой материал олсон байна (Эрдэнэбат нар 2021-2023; Erdenebat *et al.* 2022-2025; Husel *et al.* 2023).

БНХАУ-ын судалгааны хүрээнд, Хятадын зүүн хойд 3 муж, Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Хэбэй муж, Чингисийн далангийн урд шугам хүртэлх “зүүн хойд зам”, “ринхуан зам”, “баруун хойд зам”, “баруун урд зам”-тай холбоотой хэрэм далангийн талаар судалгаа хийж, тодорхой хэмжээний материал хуримтлуулжээ. Хятадын эрдэмтэд, археологийн хээрийн судалгаа болон түүхэн сурвалж бичгүүдэд тулгуурлан үзэхдээ “Чингис хааны далан” баригдсан цаг хугацааны талаар хоёр гол таамаг дэвшүүлж байна. Нэгдүгээрт, хэрэм нь Ляо улсын үед хамаарна гэж үздэг бөгөөд энэ чиглэлийн гол төлөөлөгч нь Жин Ай юм. Тэрээр, “Ляо улсын үед хойд зүгийн хүчнүүдийн довтолгооноос хамгаалж, хөдөө аж ахуйн бүс нутгийг хамгаалах зорилгоор цэргийн инженерийн байгууламж барьсан” гэсэн үзэл санааг дэвшүүлэн тавьсан болно (景愛 1982: 189). Хоёрдугаарт, уг хэрэм нь Алтан улсын үед хамаарна гэх үзэл түгээмэл байдаг бөгөөд гол төлөөлөгчид нь Ми Вэнпин, Фэн Юанцян нар юм (米文平, 冯永谦 1990: 101). Энэ үзлийг баримтлагсад, тухайлбал, Ли Пихуа энэ “Чингисийн далан” гэдэг нь “Алтан улс Монголын цэргийн эсрэг тэмцлийн хүрээнд баригдсан хамгаалалтын байгууламж” гэж үздэг (李丕华 2004: 55). Судлаач Чан Хай өөрийн бүтээлдээ, энэ хэрэм нь “Тайжоу мужийн жанжин Жан Лу Ху 1135 оны үед барьсан” хэмээн дурдсан байдаг (长海 2013). Уг хэрэм нь “Алтан улсын байгуулсан газарзүйн байрлалын хувьд хамгийн хойд хэсэгт орших цэргийн хамгаалалтын байгууламж бөгөөд анх баригдсан зорилго нь түр хугацаагаар Елюй Дашийн зүүн зүгт Ляо улсыг сэргээх цэргийн ажиллагааг хориглох зорилготой байсан ажээ.

Японы эрдэмтэн Ширазиши Нориюки, “Чингис хааны далан”-г технологийн уламжлал, бүтцийн харьцуулалт, газарзүйн үүрэг гэсэн гурван чиглэлээр авч үзэн, Ляо, Алтан улсын түүхэн сурвалж болон хээрийн судалгаанд тулгуурлан энэхүү хэрэм нь Ляо улсын үед баригдсан гэж үздэг байна. Японы судлаач Иmano Харүки, Чингисийн далангийн хойд шугам болон хятадын судлаачдын “Алтан улсын далан” гэж нэрлэж байгаа урд шугам хоёр нь хоорондоо харилцан холбоо бүхий бие биеэ нөхвөрлөх чанартай, Ляо улс нь хойд зүгийн улс үндэстний дайралт довтолгооныг нэг шугамаар ажиглан тандаж, түр хугацаанд зогсоох оролдлого хийж, тэрхүү дайралтын хурдыг намжааж цаг хожих зорилгоор хойд шугамыг байгуулсан. Тэр хооронд өмнө зүг рүүгээ үргэлжлэх мужуудын хэрэм ба хажуугийн хамгаалалтын олон хэрэм бэхлэлт рүүгээ яаралтай мэдээ хүргүүлж, довтолон ирсэн хойд зүгийн овог аймгуудыг муж нутаг, бэхлэлтийн хэрэм рүү хүрч очих хүртэлх хугацаанд бэлтгэлээ базааж, бусад олон хэрмийнхээ хамтаар угтан тулалдана. “Чингис хааны далан” бол анхнаасаа эвдэрч нурна гэсэн бодолтойгоор байгуулагдсан зүйл. Хэрэмнээс хамгаалалтын цайзын шугам хүртэлх орон зай нь цэрэг дайны довтолгооны бүс байдлаар оршдог. Хайлаар гол ба Хэрлэн голыг даган зүүн, баруун зүгт зэрэгцэн байрших олон хэрэмнүүд нь эцсийн дүндээ хамгаалалтын шугамыг бий болгож байсан гэж тайлбарлажээ (Мацукава 2021: 34; Хүсэл 2021: 136).

2019 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Баотоу хотын Соёлын дурсгалын хүрээлэн Хөх хотын Үчүань шяний Баруун Улаанбулаг сумын (西乌兰不浪镇) Цы Яо (磁窑) тосгоны Алтан улсын хилийн шуудууны Цы Яо харуулын цайзад археологийн малтлага хийжээ. Малталтаар олдсон цагаан шаазан аяга, таваг зэрэг 7 ширхэг олдвор дээр хар бэхээр бичсэн, ижил хэвтэй зүрчид бичээс илрүүлсэн байна. Эдгээр цагаан шаазан аяга, тавагны ёроолын цагирган суурин дээр бэхээр “木” гэж бичсэн байжээ. Үүнээс үзвэл тэдгээрийн зориулалтыг хоёр янзаар таамаглаж болно гэж профессор Сүн Божун үзжээ. Эхний хувилбар: Эдгээр шаазан эдлэл нь “Саби” нэртэй хүнд хамаарах эд бололтой. Хоёрдугаарт, хурим найр болон баярын үеэр ерөөл өргөхөд ашигласан эсвэл Бурханд өргөл барих сав суулга болгон хэрэглэсэн байж болно. Хийц хэлбэрийн хувьд үзвэл, эдгээр шаазан эдлэл нь цагаан паалантай хар хээтэй бөгөөд Алтан, Юань улсын үед умард нутагт түгээмэл байсан Цычжоу зуухны шаазангийн хэв маягтай ижил байв. Энэхүү нээлт нь тус газрыг үнэхээр Алтан улсын үеийн цэргийн харуул хамгаалалтын газар байсан болохыг батлах бодит баримт болж, зүрчидийн бичгийн дурсгалт зүйлийн сан хөмрөгт шинэ бодит олдворыг нэмсэн юм (Sun Bo-jun 2021: 66-69).

Чингис хааны өвөг дээдсийн үеэс Монгол

улс, Зүрчидийн Алтан улсын түрэмгий бодлогыг эсэргүүцэн тэмцэж олон жил үргэлжилсэн дайн тулалдаан хийж байсан байдаг. Монголчууд 1138 онд Алтан улсыг эсэргүүцэн тэмцэж Хайлан гэдэг газарт Алтан улсын цэргийг ялсан бөгөөд 1140, 1146 оны үед Алтан улс монголчуудыг хоёр удаа довтолж дарагджээ. “Туаньтанжилин” гэдэг сурвалжид өгүүлснээр, 1147 оны хавар Алтан улс нь Сяо Бошожу нэрт сайдыг Монголд илгээж найрамдах гэрээ байгуулжээ. Тэр гэрээ ёсоор нэгд, Алтан улс Сипин (Xipinghe) голоос хойшхи 27 цайзыг Монголд өгөх, хоёрт, жил бүр хонь, үхэр, торго бөс, амуу будааны алба үзэх болсон байна (Батсүрэн 2019: 62). Энэ гурван удаагийн тулалдаанд Монгол улс ялж Алтан улсын хилийн 27 цайзыг мэдэлдээ авсан нь өмнө Ляо улсын үед байгуулагдаж, Алтан улсын үед ашиглаж байсан хилийн шугамын тодорхой хэсгийг XII зуунаас Монголчууд эзэмшиж, тэр цагийн Зүүн Азийн түүхэнд нөлөөтэй болж ирснийг гэрчлэх юм.

2021 оны 6 дугаар сард Монгол Улсын Дорнод аймгийн Чойбалсан сумын нутаг Харнуурын бэхлэлтэнд археологич Ч.Амартүвшин, Б.Батдалай нар малталт хийж мөнгөн аяга, алтан ээмэг, бугуйвчтай эрэгтэй хүний оршуулга илрүүлэн олжээ. Тус оршуулгаас илэрсэн олдвороос C14 он цаг тогтоох лабораторийн шинжилгээ хийлгэхэд, үйсэн эдлэлээс авсан дээж 1156-1223 он, 1152-1220 он, хүний ясны дээж 1120-1218 онд холбогдоно гэсэн үр дүн гарчээ (Amartuvshin et al 2024: 9). Хар нуурын бэхлэлтээс олдсон оруулмал оршуулга нь Их Монгол Улс байгуулагдахаас өмнөх үе буюу Хамаг Монгол, Зүрчидийн Алтан улс хоёр байлдаж байх цаг үед холбогдох нь тодорхой байна.

Товч дүгнэлт

“Чингисийн далан” гэж нэрлэгддэг гурван хэрмийн хойд хоёр шугамын тухайд, түүний баригдах болсон шалтгаан, баригдсан он цаг, бүтэц зохион байгуулалтын талаар судлаачдын санал бодол будлиантай хэвээр байна. Нөгөө талаас, сурвалж бичигт энэ асуудлыг шийдвэрлэх хэмжээний бичиг тэмдэглэл хомс юм. Уг хэрмийн талаарх судалгаанууд одоохондоо тус тусдаа маягтай, харьцуулах, нэгтгэн дүгнэсэн хандлага дутагдалтай байна. Судалгааны байдлаас үзвэл, “Чингисийн далан”-гийн хойд хоёр шугамыг Хятаны Ляо улсын үед байгуулсан бөгөөд Зүрчидийн Алтан улсын үед залган ашиглаж байжээ. Энэхүү “хил хамгаалалтын шугам” нь тухайн үеийн улс төрийн хил заагийг тэмдэглэсэн эсвэл хамгаалах зорилготой инженерийн шугаман байгууламжийг илэрхийлнэ. Энэ нь зөвхөн цэрэг хамгаалалтын зориулалттай бус, тухайн бүс нутгийн хүн амын хөдөлгөөн, татварын хяналт, мал аж ахуйн зохицуулалтыг хамарсан засаг захиргааны олон талт зориулалттай байж болохыг олон

орны эрдэмтдийн судалгаа харуулж байна. Уг судалгаа нь түүхэн бичгийн эх сурвалж, археологийн мэдээлэл, газарзүйн зураглал, шинжлэх ухааны салбар дундын харьцуулсан судалгааг хослуулсан олон тулгуурт судалгааны арга зүйг ашиглах, судалгааны чиглэл нь дан ганц нэг салбарын дүгнэлтэд тулгуурлахгүй, харин бичгийн болон материаллаг эх сурвалжийн нэгдэлд суурилсан интердисциплинар (салбар хоорондын) шинжилгээнд төвлөрөх хандагатай байна.

Дундад зууны энэхүү хилийн бэхлэлтийн шугамын нэг хэсгийг 12 дугаар зууны дунд үест монголчууд булаан авч байсан гэх сурвалжийн мэдээг Дорнод аймгийн Хар нуурын бэхлэлтээс олдсон монгол булшны олдвор дам нотолж байна. Түүгээр барахгүй, онцгой байршилтай зарим бэхлэлтийг түүнээс ч хожуу ашиглаж байсан байж болохыг үгүйсгэх аргагүй, гэхдээ энэ талаар одоохондоо судалгааны баримт хангалтгүй байна.

“Чингис хааны далан” хэмээх энэхүү байгууламж нь умардын нүүдэлчин үндэстний довтолгооноос сэргийлэх, дайралтыг тогтоон барьж өмнө зүгт байгаа сэргийлэлтийн хэдэн давхар шугам хийгээд гол хот сууринд мэдээ хүргэх цаг хожих, хүн амын шилжилт хөдөлгөөнийг хянах, зам харилцаа, татвар хураалт, бэлчээрийн зохицуулалт гэх мэт олон чиг үүрэгтэй байгуулагдсан бололтой. Хожуу үед “Хэрмэн зам” хэмээх тал нутгийн зам харилцааны үүргээ одоо ч биелүүлсээр байгаа билээ.

Abstract

Some issues regarding the study of the northern border fortifications and walls of the Liao Dynasty

Chang Xiaozhen

This paper explores the historical positioning and chronological issues of construction and utilization concerning the northern border defense system of the Khitan-Liao Dynasty (Liao Dynasty, 916–1125) and its associated wall-like remains. Research indicates that the northern defensive line, commonly referred to as the “Genghis Wall” (Chengjisihan Di), was initially built during the Liao period and continued to function under the Jurchen-Jin Dynasty (1115–1234). Chinese historical records document that sections of these fortifications were breached by Mongol forces in 1147. The “Genghis Wall” likely served multiple purposes: not only as a military barrier to deter invasions from northern nomadic groups and delay enemy advances—thereby buying time for relaying intelligence to southern layered defenses and major cities—but also as an infrastructural hub for

regulating population movements, commercial flows, road traffic, tax collection, and pastureland management. To this day, this “Wall Route” across the steppe remains a vital transportation corridor.

Keywords: Khitan, Liao Dynasty, Genghis Wall, frontier fortifications

Ном зүй

Амартүвшин, Ч. (2021). “Чингисийн далан” хэмээх дурсгалт газарт ажилласан тухай (2018-2019). - in: *Mongolian and Northeast Asian Studies*. Vol. 6, Tokyo, 2021, 51-60.

Батсайхан, З., Эрдэнэбат, У., Оюунтуяа, Б. (2017). Зүбү аймаг ба Туул голын савд хийсэн хот суурины судалгаа. *Studia Archaeologica*. Tom. XXXVI, Fasc. 17. УБ.: 245-262.

Батсүрэн, Б. (2019). Монголын хант улсууд Х-ХII зуунд. Монголын эзэнт гүрний түүх (Таван боть). Тэргүүн боть: Их Монгол улс. Степпе Паблшинг, УБ.: 31-144.

Хүсэл, Б. (2021). Чингис хааны хэрэмтэй холбоотой түүхэн эх сурвалжин өнөөгийн байдал. in: *Mongolian and Northeast Asian Studies*. Vol. 6, Tokyo: 133-166.

Ковалев, А.А., Эрдэнэбаатар, Д. (2021). “Чингисийн далан” ба Өмнөговийн аймгийн нутаг дахь хэрэм, цайзын дурсгал” Тангудын Си-Ся улсын үед холбогдох нь. - in: *Mongolian and Northeast Asian Studies*. Vol. 6, Tokyo: 79-102.

Крадин, Н.Н., Харинский, А.В., Прокопец, С.Д., Ивлиев, А.Л., Ковычев, Е.В., Эрдэнэболд, Л. (2020). Хятан улсын их хэрэм. Чингисийн далангийн зүүн хойд хэсгийн судалгаа. УБ., Соёмбо принтинг

Мацукава, Т. (2021). Чингис хааны зүүн хойт далан: Түүх археологийн судлалын судалгааны өнөөгийн байдал ба тулгарч буй асуудлууд. - in: *Mongolian and Northeast Asian Studies*. Vol. 6, Tokyo: 32-40.

Пэрлээ Х. (1961). Монгол Ард Улсын эрт дундад үеийн хот суурины товчоон. УБ.

Эрдэнэбат, У., Амартүвшин, Ч., Батдалай, Б., Амарбилэг, Ч., Урангуа, Ж., Хүсэл, Б. (2021). Монгол-Японы хамтарсан “Чингис хааны далан: Олон улсын хамтын ажиллагаа” төслийн Дорнод аймгийн Чойбалсан, Цагаан-Овоо сумын нутагт хийсэн хээрийн шинжилгээний ангийн товч мэдээлэл. “Монголын археологи-2021”. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2021 оны 12-р сарын 15, 16-ны өдөр. УБ.: 64-66.

Эрдэнэбат, У., Амарбилэг, Ч., Урангуа, Ж., Хүсэл, Б., Батзориг, О. (2022). Монгол-Японы хамтарсан “Чингис хааны далан: Олон улсын хамтын ажиллагаа” төслийн 2022 оны хээрийн шинжилгээ. “Монголын археологи-2022”. Эрдэм шинжилгээний хурлын

эмхэтгэл. 2022 оны 12-р сарын 23, 24-ны өдөр. УБ.: 219-226.

Эрдэнэбат, У., Хүсэл, Б., Амарбилэг, Ч., Билгүүн, Э. (2023). “Чингис хааны далан: Олон улсын хамтын ажиллагаа” төслийн 2023 оны хээрийн шинжилгээний дүнгээс. Монголын археологи-2023. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ.: 347-351.

Amartuvshin Chunag, Gideon Shelach-Lavi, William Honeychurch, Batdalai Byambatseren, Orit Shamir, Uuriintuya Munkhtur, Daniela Wolin, Shuzhi Wang, Nofar Shamir (2024). An elite grave of the pre-Mongol period, from Dornod Province, Mongolia. In: *Archaeological Research in Asia* 39 (2024) 100537: 1-13, <https://doi.org/10.1016/j.ara.2024.100537>

Erdenebat, U., Amartuvshin, Ch., Husel Borjigin, Urangua, J., Batdalai, B., Amarbileg, Ch., Tumen, Ts. (2022). The Mongolian and Japanese Joint Research Project “The Creation of an International Joint Research of the ‘Wall of Genghis Khan’”. Survey Report of field survey team in Choibalsan and Tsagaan-Oboo soum of Dornod Province. In: “Mongolian and Northeast Asian Studies”. Vol. 7, Tokyo: 37-68 (in Japanese).

Bryan K. Hanks, Gideon Shelach-Lavi, Marc Bermann, Emily Eklund, Aspen Greaves, Chunag Amartuvshin, Narantsetseg Tserendash, Yonatan Goldsmith, Jargalan Burentogtokh, Ulambayar Erdenebat (2024). Examining Medieval Long-wall frontier systems (11th-12th centuries AD) through archaeological geophysics in the eastern Mongolian Steppe Region. In: *Journal of Archaeological Science: Reports* 60 (2024), 104860, <https://doi.org/10.1016/j.jasrep.2024.104860>

Erdenebat, U., Amartuvshin, Ch., Husel Borjigin, Urangua, J., Batdalai, B., Amarbileg, Ch., Tumen, Ts. (2022). The Mongolian and Japanese Joint Research Project “The Creation of an International Joint Research of the ‘Wall of Genghis Khan’”. Survey Report of field survey team in Choibalsan and Tsagaan-Oboo soum of Dornod Province. In: “Mongolian and Northeast Asian Studies”. Vol. 7, Tokyo: 37-68 (in Japanese)

Erdenebat, U., Husel Borjigin, Amarbileg, Ch., Bilguun, E. (2024) The Mongolian and Japanese Joint Research Project “The Creation of an International Joint Research of the ‘Wall of Genghis Khan’”. Survey Report of field survey team in Mongolia (2023). In: *Mongolian and Northeast Asian Studies*. Vol. 9, - Tokyo: 73-116 (in Japanese).

Erdenebat, U., Husel Borjigin, Zoljargal, A., Dashdorj, Takashi Matsukawa (2025). The Mongolian and Japanese Joint Research Project “The Creation of an International Joint Research of the ‘Wall of Genghis Khan’”. Survey Report of field survey team in Mongolia (2024). In: *Mongolian and Northeast Asian Studies*. Vol. 8, Tokyo: 49-76 (in Japanese).

Husel Borjigin, Erdenebat, U., Amartuvshin, Ch.,

Takashi Matsukawa, Hiroshi Futaki, Urangua, J., Batdalai, B., Amarbileg, Ch., Tumen, Ts., Ryu Takai (2023). The Mongolian and Japanese Joint Research Project “The Creation of an International Joint Research of the ‘Wall of Genghis Khan’”. Survey Report of field survey team in Dornod Province: September, 2021-March, 2022. In: Mongolian and Northeast Asian Studies. Vol. 8, Tokyo: 57-66 (in Japanese).

Gideon Shelach-Lavi, Ido Wachtel, Dan Golan, Otgonjargal Batzorig, Chunag Amartuvshin, Ronnie Ellenblum, William Honeychurch (2020). Medieval long-wall construction on the Mongolian Steppe during the eleventh to thirteenth centuries AD. In: *Antiquity*, Vol. 94, No. 375 (2020): 724–741, <https://doi.org/10.15184/aqy.2020.51>.

Sun Bo-jun (2021). A Textural Research on the Jurchen Character Unearthed in the Ruins of Kiln near the Fortress of Jin Dynasty. *Manchu Studies*, Vol. 72, No. 1,

2021, 66-69.

景爱 (1982): 《关于呼伦贝尔古边壕的探索》, 《历史地理》第3辑, 第189页

米文平、冯永谦 (1990): 《岭北长城考》, 《辽海文物学刊》1990年1期, 第101页

李丕华 (2004): 《蒙古高原边墙考》, 《东北史地》2004年第3期, 第55页。

长海 (2013): 《岭北金界壕修筑时代初析》, 《呼伦贝尔文物考古研究》(第二辑) 2013年, 第419页。

*Received: May 12, 2025; Revised: May 30, 2025;
Accepted: June 2, 2025*

